

“ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗООРЬ, АГУУЛАХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ,
ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

№ 2016/01

2016 оны 5 дугаар сарын ...-ны өдөр

Нэг. Зорилго

“Хүнсний бүтээгдэхүүний зорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын хамтарсан санамж бичгийн дагуу Монголбанк, ХХААЯ хоорондын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166/А/24 дугаар хамтарсан тушаалаар 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан. Үүний дагуу Монголбанк, банк хооронд хөтөлбөрийн зээлийн гэрээг 2013 оны 11 дүгээр сард байгуулж, санхүүжилт олгож эхэлсэн.

Дээрх хөтөлбөрийг зорь, агуулахын тоо хэмжээг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, хүнсний бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлэн, хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж эхэлсэн.

ХХААЯ-наас энэхүү хөтөлбөрт хамрагдах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, Монголбанкнаас банкаар дамжуулан санхүүжилт олгох зарчмаар хөтөлбөрийг хэрэгжүүлж ирлээ. Ингэхдээ Монголбанк банкттай байгуулсан хөтөлбөрийн зээлийн гэрээний дагуу банк жилийн 0.89%-ийн хүүтэй эх үүсвэрийг авч, хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжид жилийн 3.8%-ийн хүүтэй дамжуулан зээл олгосон.

ХХААЯ-тай “Бодлогын гэрээ” байгуулсан компани банкнаас хөтөлбөрийн эх үүсвэр авах хүсэлтээ шийдвэрлүүлж, зээлийн гэрээ байгуулсан тохиолдолд хөнгөлөлттэй хүүтэй дээрх санхүүжилтийг харилцагч банкнаас 3 жилийн хугацаатай авсан.

“Хүнсний бүтээгдэхүүний зорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр нь дараах 2 бүрэлдэхүүн хэсэгтэй:

1. Шинээр барих, өргөтгөл хийх стандартын шаардлага хангасан, хүнсний зориулалттай зорь, агуулахыг нэмэгдүүлэх;
2. Мах, сүү болон хүнсний ногоо үйлдвэрлэгч эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх.

Хүснэгт 1. Хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилт

/мянган тонн/


	Хөтөлбөр хэрэгжиж эхлэх үе	Хөтөлбөр хэрэгжиж дуусах үе	Өөрчлөлт
Нийт улсын зоорийн багтаамж	174	259	85
Шинэ технологи бүхий автомажсан зорь	23	106	83
Нойтон махны нийлүүлэлт /2-7 дугаар сард/	7	8	1
Махны үйлдвэрлэл	220	248	28
Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах	16	54	38

Хоёр. Хэрэгжилт

“Хүнсний бүтээгдэхүүний зорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш 2013 оны 11 дүгээр сараас 2014 оны 9 дүгээр сарын хооронд санхүүжилт олгогдсон бөгөөд эргэн төлөх хуваарийн дагуу хөтөлбөрийн зээл хэвийн буцаан төлөгдөж байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 66 аж ахуйн нэгжид 7 банкаар дамжуулан 137.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 64.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөтөлбөрийн хүрээнд авсан санхүүжилтээ банк сар бүр эргэн төлөх хуваарийн дагуу төлж байгаа бөгөөд хугацаа хэтрүүлсэн тохиолдол гараагүй байна /Зураг 1/.

Зураг 1. Хөтөлбөрийн зээлийн үлдэгдэл /сараар/



Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнээр дараах үр дүнд хүрээд байна. Үүнд:

- Хөтөлбөр нь 3 жилийн хугацаанд хэрэгжиж байгаа бөгөөд энэхүү хугацаанд хөтөлбөрийн үр дүнд 24 төслийн зоорийн багтаамж нийт 82,6 мянган тонноор буюу 47%-иар нэмэгдсэн байна.
- Автомат, хагас автомат удирдлагатай, иж бүрэн механикжсан ажиллагаатай төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний зоорь, агуулах, худалдааны төвүүдийг байгуулснаар:
 - Төмс, хүнсний ногооны зоорь 64,5 мянган тонноор, мах махан бүтээгдэхүүний хөргүүртэй зоорь 15,1 мянган тонноор тус тус нэмэгдсэн байна.
 - Төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж 37%-иар нэмэгдэж 238,1 мянган тоннд хүрсэн.
- Эрчимжсэн аж ахуйн нэгжийн 32 төслийн хүрээнд 2014 онд 6 мян.тн, 2015 онд 6.8 мян.тн нойтон мах нийлүүлсэн бол, 2016 онд 7.7 мян.тн нойтон мах нийлүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ нь гол төлөв 2-7 дугаар сарын нойтон махны нийлүүлэлтийг 15 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй.

“Хүнсний бүтээгдэхүүний зоорь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд дараах 2 зориулалтаар санхүүжилт олгосон:

1. Шинээр барих, өргөтгөл хийх стандартын шаардлага хангасан, хүнсний зориулалттай зоорь, агуулахыг нэмэгдүүлэхэд зориулан 25 аж ахуйн нэгжид 73.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 28.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна;
2. Мах, сүү болон хүнсний ногоо үйлдвэрлэгч эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэхэд зориулан 41 аж ахуйн нэгжид 63.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 35.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Гурав. Дүгнэлт

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт төсөл хэрэгжүүлэгч Мах, махан бүтээгдэхүүний зоорь, агуулахын чиглэлээр 14 аж ахуйн нэгж байгаагаас 12 аж ахуйн нэгж, Төмс, хүнсний ногооны агуулах зоорийн чиглэлээр 12 аж ахуйн нэгжээс 6 аж ахуйн нэгж тус тус ажлаа дуусгасан байна.

Эдгээр хөтөлбөр хэрэгжиж эхлээд мах, махан бүтээгдэхүүний зоорь, агуулах 19.5 мянган тонноор, хүнсний ногооны зоорь 66.5 мянган тонноор, худалдааны төвийн агуулахын

багтаамж 6.0 мянган тонноор тус тус нэмэгдсэн. Хүнсний ногооны зоорийн багтаамж 37 хувиар нэмэгдэж 248,7 мянган тоннд хүрч жилд хураан авах хүнсний ногооны зoorь, агуулахын хангамж 71 хувьд хүрэх төлөвлөгөөтэй байна. Мөн махны чиглэлийн үхрийн ферм 32-оор, цэвэр, эрлийз үхрийн тоо 11500 толгойгоор нэмэгдсэн.

Харин эрчимжсэн аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд 2016 оноос эхлэн жил бүрийн 1-7 дугаар сарын хооронд нийслэлийн хүн амын махны хэрэгцээнд нийлүүлэх нойтон махны хэмжээг 7 мянган тонноор нэмэгдүүлэх зорилттой. Шинээр аж ахуйн нэгж бий болсноор дунджаар 5 ажлын байр нэмэгдэж 120 хүн байнгын ажилтай болоод байна.


Түүнчлэн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлсэнээр Гахай, шувууны аж ахуйн тэжээлийн микро элементүүдээс бусдыг дотооддоо үйлдвэрлэн импортоор авах өндөг, гахай, шувууны махыг дотооддоо үйлдвэрлэж байна. Түмэн шувуут ХХК-ийн цагт 12 тонн тахианы тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр ашиглалтад орсоноор тахианы тэжээлийг дотооддоо бүрэн үйлдвэрлэж байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурлын 2014 оны 69 дүгээр тогтоолын 5 дахь заалт /Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай/, 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн 2.1 дэх заалтын /Хөтөлбөрийн зээлээс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт шилжүүлэх 2015 оны эхний хагаст/ дагуу 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Монгол Улсын Засгийн газарт шилжүүлэхээр заасан.

Иймээс УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж Монгол Улсын Хөгжлийн банкинд шилжүүлэх шаардлагатай байна.

Зураг 2. Хөтөлбөрийн зээлийн эргэн төлөх хуваарь



Хөтөлбөрийн зээлийн эргэн төлөх хуваарийн дагуу 2017 оны 9 дүгээр сард бүрэн төлөгдөж дуусна.